



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА  
Ш.ИДЭРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@jaac.mn, Вэб сайт: http://jaac.mn

2022 04 04 № 05/4577  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Түмэнбаярын Октябрьбаярын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Т.Октябрьбаяр нь Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журамд заасны дагуу сонгон шалгаруулалтад хамрагдаагүй байх тул нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийг томилоход Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Т.ЭНХБОЛД